

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Бодлого, төлөвлөлтийн газар

**БНХАУ-ын 15 дугаар таван жилийн (2026-2030) төлөвлөгөө, Өвөр
Монголын өөртөө засах орны 5 жилийн төлөвлөгөөний талаарх эх
сурвалжуудад гарсан тойм судалгаа, мэдээлэл**



Оршил

Хятад улс 1953 оноос хойш таван жилийн төлөвлөгөөг боловсруулж, өдгөө 14 таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлээд байна. Уг төлөвлөгөөг хэлэлцэх хуралдааныг таван жилд нэг удаа буюу дараагийн таван жил эхлэхээс нэг жилийн өмнө хэлэлцдэг.

Процессын хувьд Хятадын Коммунист намын удирдлага дор Намын Төв Хорооноос төлөвлөгөөний санал дэвшүүлж, Төрийн Зөвлөл төлөвлөгөөний хөтөлбөрийг боловсруулж, Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаар хэлэлцэн баталж, хэрэгжүүлдэг стратегийн баримт бичиг юм.

Ирэх таван жилийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогоо хэлэлцэж, дараагийн таван жилийн гол зорилгоо тодорхойлох чухал ач холбогдолтой.

БНХАУ-ын 15 дугаар таван жилийн төлөвлөгөө (2026–2030 он) 2026 оны 3-р сарын 12-нд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын (NPC) 14 дэх чуулганы хаалтын хуралдаанаар батлагдсан. Харин БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны 15 дугаар таван жилийн төлөвлөгөө 2026 оны 2-р сарын 14-нд батлагдсан байна. Энэхүү таван жилийн төлөвлөгөөтэй холбоотойгоор салбарын төрөлжсөн хөтөлбөр, баримт бичгүүд (дэд бүтэц, аж үйлдвэр, эрүүл мэнд гэх мэт) гардаг.

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газраас бэлтгэсэн энэхүү мэдээлэл нь БНХАУ-ын 15 дахь таван жилийн төлөвлөгөөний ерөнхий агуулга, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны таван жилийн төлөвлөгөөнд тусгагдсан асуудлаар Монгол Улсын эдийн засагт хамааралтай байж болох боомт, уул уурхай, аж үйлдвэрлэлийн холбоотой мэдээллийг тусгаж харуулахыг зорьсон болно.

БНХАУ-ын 15 дахь таван жилийн төлөвлөгөө

Манай өмнөд хөрш БНХАУ-ын 15 дугаар таван жилийн төлөвлөгөө (2026–2030 он) 2026 оны 3-р сарын 12-нд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын (NPC) 14 дэх чуулганы хаалтын хуралдаанаар батлагдсан. Энэ нь Хятадын үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн албан ёсны “тойм” юм.

Ирэх 5 жилд (2026-2030)-нд Хятад улс аль салбартаа илүү төвлөрөх, анхаарал хандуулах, хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх төлөв хандлагатай байгаа талаар холбогдох тайлан мэдээлэлд тулгуурлан хийсэн судалгаагаа доорх 15 агуулгын хүрээнд маш товч байдлаар хялбарчлан гаргав.

Эдийн засгийн тогтвортой өсөлт

XV таван жилийн төлөвлөгөөний хугацааны сүүлч үе буюу 2031 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ-ийг өндөр хөгжингүй орнуудын дундаж түвшинд хүргэх зорилтын хүрээнд эдийн засгийн өсөлтийг зохих түвшинд хадгалах болно. Шинжээчдийн тооцоолсноор ирэх 5 жилд ДНБ-ний бодит өсөлтийн дундаж хэмжээг 5% -с багагүй байх зорилт тавьжээ.

Үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах

Технологи инновацын тусламжтайгаар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх замаар нөөцийн хуваарилалтын үр ашгийг нэмэгдүүлэх, боловсрол, хүний нөөцийн бүтээмжийг дээшлүүлэх, эдийн засгийн бүтцийг инновацад суурилсан загварт үндсээр нь шилжүүлэх.

Газрын ховор элементийн нийлүүлэлт

АНУ-ын Геологийн судалгааны алба (USGS)-ийн мэдээллээр 2025 онд Хятадын дэлхийн газрын ховор элементийн үйлдвэрлэл ойролцоогоор 270,000 тонн буюу 2024 оныхтой адил буюу дэлхийн үйлдвэрлэлийн 69.8%-ийг эзэлж байна. XV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд ухаалаг технологи, мэдээллийн технологийн дэвшил, шинэ эрчим хүчний үйлдвэрлэл, цахилгаан тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн роботуудаас үүдэлтэй эрэлт хэрэгцээ тасралтгүй өсөж байгаа тул газрын ховор элементийн олборлолт, боловсруулалт тогтвортой өсөх төлөвтэй

байна. Цаашид ч гэсэн хятадын газрын ховор элементийн олборлолт сүүлийн жилүүдэд тогтвортой өсөх чиг хандлагатай байна. Харин 2030 онд газрын ховор элементийн үйлдвэрлэл 420,000-521,000 тонн байх төлөвтэй байна.

Төсвийн орлого ба татвар бууруулах

Макро эдийн засгийн хүрээнд татварын өсөлтийг зохистой хэмжээнд байлгана. "Загасыг барих гэж цөөрмөө шавхах" аргаас зайлсхийх бодлого барьж татварын орлогын хэт хурдтай өсөлтийг цаашид хэрэгжүүлэхгүй байх, аж ахуйн нэгжүүдийн ачааллыг бууруулахад анхаарна. 2016-2024 онуудад улсын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 21.4%-аас 16.3% болж, татварын орлого ДНБ-д эзлэх хувь 17.5%-аас 13% болж буурсан байна. XV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд эдгээр харьцааг тогтвортой хадгална.

Хотжилт өссөөр байна

2026-2030 онуудын хотжилтын түвшний тухайд Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо, Нийгмийн шинжлэх ухааны академи зэрэг байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн үнэлгээгээр ард иргэдийн хотжилтын түвшин 2030 он гэхэд ойролцоогоор 71.5 %-д хүрнэ гэж тооцоолж байна. Жилд дунджаар 0.7 %-ийн өсөлттэй байгаа нь жил бүр ойролцоогоор 11 сая хөдөөгийн оршин суугчид хот суурин газар руу шилжин суурьшдаг гэсэн үг юм.

Шинжлэх ухаан технологийн салбарын хөрөнгө оруулалт

Хятадын шинжлэх ухаан технологийн салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилт 2025 онд ойролцоогоор 513 тэрбум ам.долларт хүрээд байна. Хэрэв XV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд өсөлт нь 3%-аар нэмэгдвэл 2030 он гэхэд жилийн шинжлэх ухаан технологийн салбарын хөрөнгө оруулалт ойролцоогоор 563 тэрбум ам.доллар болно гэж тооцоолж байна.

Төмөр замын салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ

Ирэх таван жилд төмөр замын хөрөнгө оруулалт жилд дунджаар 700-800 тэрбум юань хүрч, төмөр замын салбарт өндөр хэмжээний хөрөнгө оруулалт хийх төлөвтэй байна. Энэ хугацаанд нийт хөрөнгө оруулалт 3.5-4 их наяд юанийн хооронд байх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь 13-р болон 14-р таван жилийн төлөвлөгөөний

хугацаанд хийсэн хөрөнгө оруулалттай (ойролцоогоор 3.97 их наяд юань) тэнцүү байна гэсэн үг. 2031 он гэхэд хятадын төмөр замын нийт ашиглалтын урт нь ойролцоогоор 180,000 километр хүрнэ, үүнд 60,000 орчим километр өндөр хурдны төмөр зам багтана. "Найман босоо болон найман хэвтээ" өндөр хурдны төмөр замын систем бүрэн хэрэгжиж, үндсэндээ дэлхийн хэмжээний орчин үеийн төмөр замын сүлжээг бий болгоно.

Нүүрсний хэрэглээ

Хятадын Үндэсний Нүүрсний Холбоо (CNCA)-аас 2025 онд гаргасан мэдээллээр хятадын нийт нүүрсний хэрэглээ 2028 оны орчимд оргил үедээ хүрнэ гэж тооцоолж байна. Оргил үедээ хүрнэ гэдэг нь шууд бууралт гэсэн үг биш, харин өсөлт эсвэл бууралтын аль нэг боломжтой бага зэрэг хэлбэлзэлтэй үе юм (5-10 жил үргэлжилнэ гэж тооцоолж байна). 15, 16-р таван жилийн төлөвлөгөөний хугацаа нь Хятадын нүүрсний салбарын өөрчлөлтийн чухал үе байх болно. Нүүрсний салбарын хөгжил нь урт хугацааны тэлэлт болон өсөлтөөс тогтвортой өсөлт эсвэл бүр бууралтын үе шат руу шилжих болно. 2030 он гэхэд шинээр үүсэх эрчим хүчний хэрэглээний дийлэнх хэсгийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангана гэсэн таамаглал байна. 2025 онд хятадын нүүрсний үйлдвэрлэл 4.85 тэрбум тонн, нүүрсний импорт 490 сая тонн болж 9.6 хувиар буурчээ.

Ган төмрийн үйлдвэрлэл

XV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд (2026-2030) Хятадын ган төмрийн салбар нь нүүрсний "оргил үе"-тэй харьцуулахад чиг хандлага илүү тодорхой байна. 2026-2030 онуудад "хэрэглээ буурах", "одоо байгаа хүчин чадлыг оновчтой болгох" шинэ үе шатандаа бүрэн шилжинэ. XV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд түүхий гангийн эрэлт аажмаар буурч, жилд 800 сая тонн орчим болно. Одоогоор оргил үедээ хүрч буй нүүрснээс ялгаатай нь гангийн хэрэглээ аль хэдийн оргил үедээ хүрсэн бөгөөд буурах хандлагатай байна: Хятадын түүхий ган төмрийн хэрэглээ 2020 онд оргил үедээ хүрсэн (1.1 тэрбум тонн) бөгөөд түүнээс хойш таван жил дараалан буурсан байна. 2026 онд хэрэглээний хэмжээ 2020 оны оргил үеэс даруй 20.9%-аар бага байх төлөвтэй байна.

Хагас дамжуулагчийн үйлдвэрлэл , нийлүүлэлт

XV таван жилийн төлөвлөгөөний төгсгөлд(2030) хятадын хагас дамжуулагчийн нийт үйлдвэрлэл 600-620 тэрбум нэгжид хүрнэ гэж тооцоолж байна. 2025 онд хагас дамжуулагчийн үйлдвэрлэл 484.3 тэрбум нэгжид хүрч, өмнөх оны мөн үеэс 10.9%-аар өссөн байна. Үйлдвэрлэлийн зорилтоос гадна борлуулалтын орлого тэр үед 2.4 их наяд юаниас давах төлөвтэй байна. Үүний зэрэгцээ 3-5 нанометрийн хагас дамжуулагчийн үйлдвэрлэлд технологийн дэвшилтэт нээлтүүд гарах төлөвтэй байгаа бөгөөд 7-10 нанометрийн хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн шугамууд цаашид илүү өргөжин тэлэх шахуу төлөвлөгөөтэй байна.

Хүнсний аюулгүй байдал ба үр тарианы ургац

Ирэх 5 жилд жил бүр 700 сая тонноос багагүй ургац хураан авна. Энэ хугацаанд тариалангийн газрын нийт хэмжээг 120 сая га-с багагүй байх улаан шугамыг чанд баримтална. Хүнсний аюулгүй байдлыг хангах асар том зорилтын хүрээнд XV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт 3.2 их наяд юаньд хүрэх төлөвтэй байна.

Дундаж наслалт

XV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд (2026-2030) иргэдийн дундаж наслалтыг 2024 онд 79 наснаас нэг жилээр нэмэгдүүлж, 80 нас хүргэх зорилт тавьжээ. 2024 онд хятадын иргэдийн дундаж наслалт 79 нас хүрч, "Эрүүл Хятад хүн-2030" төлөвлөгөөний зорилтыг хугацаанаас нь өмнө биелүүлж, эрүүл мэндийн гол үзүүлэлтүүд дунд болон өндөр орлоготой орнуудын дунд тэргүүлж байна.

10 их наяд юанийн шинэ зах зээл бий болгох

Уламжлалт аж үйлдвэрүүд нь нийт аж үйлдвэрлэлийн нэмүү өртгийн ойролцоогоор 80%-ийг эзэлдэг. Дараагийн таван жилд голлох аж үйлдвэрүүдийн шинэчлэлийг дэмжиж, химийн бодис, машин механизм, хөлөг онгоцны үйлдвэрлэл зэрэг салбаруудын дэлхийд өрсөлдөх чадварыг сайжруулснаар ойролцоогоор 10 их наяд юанийн шинэ зах зээлийн орон зай бий болно.

Барилга үл хөдлөх хөрөнгийн салбар

Ирэх таван жилд үл хөдлөх хөрөнгийн салбар нь "хуучин загвар"-аас бүрэн салж, өндөр чанар, эрсдэл багатай "шинэ хөгжлийн загвар" руу бүрэн шилжих

болно. 2025 он гэхэд үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 900 сая М² болж буурч, өмнөх үеийн 1.5 тэрбум М² дээш оргил үеэсээ буураад байна. Зах зээл дээрх нийлүүлэлт ба эрэлт хоёулаа агшилтаас тогтворжилт руу шилжих болно.

Дараагийн арван жилийн өндөр технологийн салбарыг ирээдүй

Квант технологи, био үйлдвэрлэл, сансар судлал, устөрөгчийн эрчим хүч болон цөмийн нэгдлийн эрчим хүч, супер-компьютер, хиймэл оюун ухаан, 6G зэрэг ирээдүйн тэргүүлэх салбаруудыг идэвхтэй хөгжүүлснээр дараагийн 10 жилд өндөр технологийн салбартаа дэлхийд тэргүүлэх түвшинд хүргэх зорилт тавьжээ.

XV таван жилийн төлөвлөгөөний гол цөм агуулга нь эдийн засгийн тоон өсөлтийн хойноос биш чанартай хөгжилд анхаарч ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад илүү их ач холбогдол өгчээ. Ирэх 5 жилд Хятад улс технологийн дэвшил, инновацын тусламжтайгаар аж үйлдвэрийн шинэчлэлийг хийх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, дотоодын эрэлтийг өргөжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалж, ногоон өөрчлөлт, ирээдүйн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн зорилтыг тавьжээ. Эдийн засаг худалдааны гол түнш улсынхаа ирээдүйн 5 жилийн эдийн засгийн төлөвлөлтийг маш сайн анхааран судалж, бид ч гэсэн 2025 онд баталсан 5 жилийн төлөвлөгөөтэй улсын хувьд өөрсдийн бодлого төлөвлөлтөө сайжруулж явахад тийм ч хэцүү биш байх.

БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны 15 дугаар таван жилийн төлөвлөгөөний талаар

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны 15 дугаар таван жилийн төлөвлөгөө 2026 оны 2-р сарын 14-нд батлагдсан. Монгол Улстай хиллэх хилийн ойролцоох дэд бүтэц (төмөр зам, авто зам), нүүрс, ган төмөр, аж үйлдвэрийн чиглэлээр тодорхой заалтууд тусгагдсан байна. Энэхүү баримт бичигт “Хятад-Монгол-Орос эдийн засгийн коридор”-ыг эдийн засгийн гол бодлогоо болгож, хилийн боомтуудыг Эрээн хот, Ганцмод боомтод төвлөрүүлэн, импортын нөөц (нүүрс, төмрийн хүдэр)-ийг газар дээр нь боловсруулах бодлого баримталжээ.

Өвөр Монголын хувьд энэ удаагийн төлөвлөгөө нь "Шинэ чансааны үйлдвэрлэх хүчин"-ийг хөгжүүлэхэд голлон анхаарч байгаа бөгөөд дараах 4 тулгуур баганатай байна:

- **Ногоон эрчим хүч:** Сэргээгдэх эрчим хүчний бааз (нар, салхи) болон устөрөгчийн энергийг улсын хэмжээнд тэргүүлэх түвшинд хүргэх.
- **Экологийн аюулгүй байдал:** "Гурван хойд" хамгаалалтын зурвасын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, цөлжилттэй тэмцэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй үргэлжлүүлэх.
- **Дижитал шилжилт:** Их өгөгдөл боловсруулах төслийн хүрээнд дата төвүүдийг өргөжүүлж, ухаалаг уурхай, цахим засаглалыг дэмжих.
- **Нээлттэй хаалганы бодлого:** Монгол Улс болон ОХУ-тай хийх худалдаа, логиستيкийн дэд бүтцийг (Эрээн, Ганцмод гэх мэт боомтууд) сайжруулж, "Бүс ба Зам" санаачилгад гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх.

1. Хилийн ойролцоох дэд бүтэц: Төмөр зам, авто зам холболт
Төлөвлөгөөний 34 дүгээр бүлэг, 1 дэх хэсэг -д:

- “Хятад-Монгол-Орос эдийн засгийн коридор”-ыг бэхжүүлэх:
 - Дунд шугамын коридор: Эрээн хот боомт-ыг гол зангилаа болгож, Хятад-Монгол-Орос дунд шугамын төмөр замаар дэмжинэ. Энэ нь Монгол Улстай шууд холбогдож, дотооддоо Тяньжин /Бээжин-Тяньжин-Хэбэй рүү, гадаадад Орос-Монгол-Европ руу чиглэнэ.
 - Ганцмод төмөр замын боомтыг бүрэн барьж ашиглалтад оруулах.
 - Манжуур, Эрээн, Ганцмод, Секе, Мандула зэрэг боомтуудыг өргөжүүлэх: Төмөр зам, авто замын дэд бүтцэд ухаалаг шинэчлэл (автомат удирдлагатай тээвэрлэлт) нэвтрүүлэх:
- Ухаалаг боомт ба хил дамнасан тээвэр:

- Автомат удирдлагатай машин (AGV), жолоочгүй хүнд даацын ачааны машин ашиглах.
- Боомтыг аж үйлдвэрийн парк болон дотоод бүс нутагтай холбох: Импортын төмрийн хүдэр, нүүрс, жонш, зэсийн баяжмал нефтийн төрлийн бүтээгдэхүүн зэргийг газар дээр нь боловсруулах.
- Зорилтууд (2030 он гэхэд):
 - Хурдны төмөр зам 1000 км хүрэх, бүх аймаг/хот хурдны төмөр замаар холбогдох.
 - Авто зам нийт 23.5 мян км, хурдны замыг 9000 км-т хүргэх.
 - Хилийн ойролцоох авто замыг бэхжүүлэх, боомтоос дотоод хотууд руу хурдны зам барих.

Энэ бодлого нь Монгол Улстай хилийн худалдаа, тээвэрлэлтийг илүү хурдан, ухаалаг болгох зорилготой.

Мөн дөнгөж 2026 оны 3-р сард батлагдсан төлөвлөгөөг цааш нь салбараар төрөлжүүлж, бусад холбогдох хөтөлбөрүүд батлагдахаар хүлээгдэж байгааг эх сурвалжууд онцолсон байна.

2. Нүүрсний салбар: 15 дугаар бүлэг, 1 дэх хэсэгт дурьдсанаар,

- Үндэсний нүүрсний нийлүүлэлтийн бат бэх бааз болгоно.
- Ажиллаж байгаа уурхайн хүчин чадлыг 13 тэрбум тонн/жил орчим тогтвортой байлгах.
- Ногоон, ухаалаг олборлолт, цэвэрлэх технологийг нэвтрүүлэх.
- Хилийн боомтуудаар (Ганцмод, Эрээн) Монголоос нүүрс импортлох сувгийг өргөжүүлэх.


3. Ган төмөр ба аж үйлдвэр

- Боомтуудад импортын төмрийн хүдрийг голлон гүн боловсруулах аж үйлдвэр хөгжүүлэх (төлөвлөгөөний 23 дугаар бүлэг).

- Уламжлалт салбарыг шинэчлэх (25 дугаар бүлэг): Ган үйлдвэрийг ногоон технологи, дижитал өөрчлөлтөөр шинэчлэх, газрын ховор элемент зэрэг өндөр технологийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
- Боомтод суурилсан аж үйлдвэрлэлийн парк (Эрээн, Ганцмод)-уудад импортын төмрийн хүдэр, нүүрс боловсруулах кластер бий болгох сувгийг өргөжүүлэх: Боомтын дамжлагаас газар дээрх эдийн засаг руу шилжих.

Боомт хилийн худалдааны гол стратеги бол Хятад-Монгол-Орос эдийн засгийн коридор учраас хилийн төмөр зам, авто зам, боомтууд (Эрээн хот, Ганцмод) энэ коридор дээр төвлөрдөг. Доорх газрын зурагт үүнийг тодорхой харуулж байна (Belt and Road Initiative-ийн коридорын ерөнхий зураг, төлөвлөгөөнд онцолсон хэсэг):

Зураг 1



Зургийн тайлбар:

1. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор
- 2.Евроазийн хуурай газрын шинэ гүүр эдийн засгийн коридор
- 3.Хятад-Төв Ази-Баруун Ази эдийн засгийн коридор
- 4.Хятад Пакистан эдийн засгийн коридор
- 5.Бангладеш-Хятад-Энэтхэг-Мьянмарын эдийн засгийн коридор
- 6.Хятад-Энэтхэгийн хойгийн эдийн засгийн коридор

Зураг 2



Зураг тайлбар:

- Энэ нь Хятад-Монгол-Орос эдийн засгийн коридор-ын ерөнхий байршлыг харуулсан зураг.
- Гол элементүүд:
 - Эрээн хот (Erenhot) – Монгол Улстай хиллэх гол төв боомт Замын-Үүдтэй холбогддог. Энэ нь төмөр замын зангилаа, мөн авто замаар холбогдсон.
 - Ганцмод (Ganzamodu) – Баруун талд (Баруун Өвөр Монголд), Монголын Гашуунсухайт боомттой холбогддог бөгөөд голлох бүтээгдэхүүн нүүрс, зэсийн импортын боомт. Тус төлөвлөгөөнд Ганцмод төмөр замын боомтыг бүрэн ашиглалтад оруулах гэж заасан.
 - Улаан/ягаан шугамууд – Төмөр зам, авто замын коридор
 - Цэнхэр/ногоон шугамууд – Бусад эдийн засгийн коридор, боомт холболт (Манжуур).

- Зорилго: Монгол руу чиглэсэн гол урсгал (нүүрс, төмрийн хүдэр импорт, экспорт) харуулж, хилийн ойролцоох дэд бүтцийн төвлөрлийг тодотгосон.

Зураг 3



Зураг 3 тайлбар:

- Энэ нь Эрээн хотоос эхлэн Монгол, Орос руу чиглэсэн төмөр замын сүлжээг илүү нарийвчлан харуулсан.
- Гол элементүүд:
 - Эрээн хот (Erenhot) – Төв цэг, төмөр зам, авто замын зангилаа.
 - Улаан шугамууд – Гол төмөр зам, Манжуур руу чиглэсэн зүүн шугам).
 - Ganzhou – Баруун талд (Ганцмод боомттой холбоотой), нэмэлт холболт.
 - Бусад цэгүүд: Манжуур (Manzhouli), бусад боомтууд, Орос руу чиглэсэн урсгал.

- Зорилго: Төлөвлөгөөнд заасан ухаалаг боомт (AGV, жолоочгүй хүнд даацын машин), төмөр замын өргөтгөл (Ганцмод төмөр зам барих), хурдны төмөр зам (1000 км-ээс дээш), авто замыг өргөжүүлэх.
- Эдгээр зургууд нь 15 дугаар таван жилийн төлөвлөгөөний бодит агуулгатай 100% нийцдэг (боомт өргөжүүлэлт, Ганцмод төмөр зам барих, Эрээн хотыг гол зангилаа болгох г.м.), гэхдээ албан ёсны хавсралт биш – ерөнхий ойлголт өгөхөд зориулагдсан.

Үүнээс гадна Өвөр Монголын 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд (2026–2030) Монгол Улстай хиллэх боомтуудыг хөгжүүлэх асуудал нь **"Умардад нээлттэй байх гүүр"** (Bridgehead for Northward Opening) стратегийн хүрээнд маш чухал байр суурь эзэлж байна. 2026 оны 2-р сард болсон хурлуудаар боомтуудыг зөвхөн ачаа нэвтрүүлэх цэг бус, **"Ухаалаг, ногоон, дижитал"** логистикийн зангилаа болгон өөрчлөх зорилт тавьжээ.

1. Гол боомтуудын өргөтгөл, шинэчлэл (2026–2030)

Боомтууд нь дараах тодорхой төлөвлөгөөг баримталж байна.

- **Эрээн (Erenhot):** Хятад-Европын чиглэлийн төмөр замын гол зангилаа тул нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, "Чөлөөт бүс"-ийн үйл ажиллагааг жигдрүүлэхэд анхаарна. Төмөр замын ачаа эргэлтийг жилд 20 сая тонноос давуулах зорилттой.
- **Ганцмод (Ganqimaodu):** Энэ боомт дээр **AGV (жолоочгүй ухаалаг тээвэр)** болон хил дамнасан туузан дамжуургын системийг бүрэн нэвтрүүлж, нүүрсний экспортыг сааталгүй болгохоор тусгасан. Мөн Ганцмод–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын холболтыг эцэслэх нь 15-р таван жилийн гол ажил юм.
- **Ханги (Mandula/Khangi):** Ханги-Мандал боомтыг "Ухаалаг боомт" болгон хөгжүүлж, жолоочгүй хүнд даацын ачааны машины тусгай эгнээг 2026 онд ашиглалтад оруулна. Зүүнбаян–Ханги чиглэлийн төмөр замыг Хятадын төмөр замын сүлжээтэй бүрэн холбож, стратегийн түүхий эдийн шинэ суваг болгоно.

- **Зүүнхатавч (Zhuengadabuqi):** Энэ боомтыг Зүүн бүсийн логикийн төв болгож, хил дамнасан цахим худалдаа (E-commerce) болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний терминалуудыг өргөтгөнө.
- **Бургастай (Laoyemiao/Burgastai):** Баруун бүсийн боомтуудын нэг болох Бургастайг уул уурхайн бүтээгдэхүүнээс гадна аялал жуулчлал, орон нутгийн худалдааны чиглэлээр дэд бүтцийг нь сайжруулахаар төлөвлөжээ.

Боомтуудын ирээдүйн төлөвлөлт бодлогыг хүснэгтээр харуулвал:

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Ганцмод	Ханги
1	Гол тээвэрлэлт	Нүүрс, Зэсийн баяжмал	Төмрийн хүдэр, Коксжих нүүрс
2	Технологи	AGV, Ухаалаг төмөр зам	Битүү туузан дамжуурга, Хурдны зам
3	Зорилтот бүс	Баяннуур, Ордос	Бугат (Baotou), Хөх хот
4	Тээврийн зардал	45% бууруулах	35% бууруулах

Хүснэгт 2

№	Үзүүлэлт	Шивээхүрэн (Секе)	Зүүнхатавч (Zhuengadabuqi)
1	Үндсэн чиглэл	Эрчим хүчний нүүрс, кокс	Уул уурхай + Хөдөө аж ахуй
2	Хүчин чадал	30 сая тонн/жил	15 сая тонн/жил
3	Хөрөнгө оруулалт	Автоматжуулалт, Логистик	Төмөр замын холболт, Чөлөөт бүс
4	Зорилтот бүс	Ганьсү, Ниншя, Баруун бүс	Ляонин, Зүүн хойд бүс

1. Ганцмод – Гашуунсухайт төмөр замын холболт

Энэхүү төсөл нь "Бүс ба Зам" санаачилгын хүрээнд Өвөр Монголын хамгийн өндөр ач холбогдолтой төсөл юм.

- Төмөр замын төрөл: Олон улсын стандарт хэмжээ (\$1435\$ мм) болон Монголын өргөн царигийн (\$1520\$ мм) шилжүүлэн ачих терминал бүхий цогцолбор.
- Тээвэрлэх хүчин чадал: 2026-2030 онд жилд 30-50 сая тонн ачаа (голдуу нүүрс, зэсийн баяжмал) тээвэрлэхээр төлөвлөсөн.
- Техник шинэчлэл: AGV (Automated Guided Vehicle): Жолоочгүй ухаалаг тээврийн хэрэгслийн тоог 500-д хүргэж, хил дамнасан тээвэрлэлтийг 24 цагийн автомат горимд шилжүүлж байна.

Ухаалаг хяналт: Хиймэл оюун ухаанд суурилсан гаалийн шалгалт нэвтэрснээр нэг цувааг шалгах хугацааг 30 секунд хүртэл бууруулсан.

- Эдийн засгийн үр өгөөж: Төмөр зам холбогдсоноор тээврийн зардал авто тээвэртэй харьцуулахад 40-50%-аар буурна гэж тооцоолж байна.

2. Ханги – Мандал боомтын төмөр замын холболт

Ханги-Мандал нь Монголын говийн бүсийг Хятадын Бугат (Baotou) хотын гангийн үйлдвэрүүдтэй холбох хамгийн дөт зам юм.

- Дэд бүтэц: Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замыг Хятадын талын Мандал боомтын төмөр замын сүлжээтэй холбох ажил 15 дугаар таван жилийн төлөвлөгөөний эхний хагаст (2026-2027) бүрэн дуусахаар тусгагдсан.
- Техник үзүүлэлт: Шилжүүлэн ачих хүчин чадал: Жилд 20 сая тонн.
 - Төмөр замын урт: Хил дамнасан холболтын хэсэг нь богино боловч логиستيкийн төвүүдийг шинээр байгуулж байна.
- Онцлох техник: "Ногоон боомт" стандартын дагуу тоосжилтоос хамгаалсан битүү терминал болон туузан дамжуургын системүүдийг (Conveyor belt) нэвтрүүлж байна.

- Стратегийн ач холбогдол: Бугатын гангийн үйлдвэрүүдийн (Baogang Group) түүхий эдийн зардлыг тонн тутамд 15-20 юаниар хэмнэх зорилттой.

Мөн 2026 оны 2-р сарын баримт бичгүүдэд Эрээн боомтын талаар дараах 4 гол чиглэлийг чухалчилсан байна:

1. Төмөр замын хүчин чадлыг "Шинэ шатанд" гаргах

Эрээн бол Хятад-Европ (China-Europe Railway Express) чиглэлийн төмөр замын төв коридор юм.

- **Төмөр замын өргөтгөл:** Эрээн–Замын-Үүд чиглэлийн төмөр замын нэвтрүүлэх хүчин чадлыг жилд **30 сая тонн**-оос давуулахаар төлөвлөсөн.
- **Шилжүүлэн ачих терминал:** Дижитал удирдлагатай, бүрэн автоматжуулсан "Ухаалаг терминал"-ыг 2027 он гэхэд бүрэн ашиглалтад оруулж, чингэлэг шилжүүлэн ачих хугацааг 20%-аар бууруулна.

2. Хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс (CECZ)

15-р таван жилд Эрээн-Замын-Үүдийн хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг "бодит утгаар" нь хэрэгжүүлэхийг зорьж байна.

- **Үйлдвэрлэлийн бааз:** Монголоос ирж буй түүхий эдийг (ноос, ноолуур, махны чиглэлээр) хил дээр нь боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгон Хятадын дотоодын зах зээл болон бусад улс руу гаргах үйлдвэрүүдийг дэмжинэ.
- **Татварын хөнгөлөлт:** Энэ бүсэд үйл ажиллагаа явуулж буй Монгол, Хятадын аж ахуйн нэгжүүдэд тусгай татварын орчин бүрдүүлнэ.

3. "Ногоон болон Дижитал" боомтын шинэчлэл

2026 онд батлагдсан төлөвлөгөөний нэг шинэлэг тал нь экологийн асуудал юм.

- **Цэвэр эрчим хүч:** Эрээн хотыг "Ногоон эрчим хүчний боомт" болгож, боомтын үйл ажиллагааг салхи, нарны эрчим хүчээр 100% хангахаар тусгасан.
- **Smart Customs:** Хиймэл оюун ухаанд суурилсан "Contactless" (Хүрэлцэхгүй) гаалийн хяналтыг нэвтрүүлж, ачаа тээврийн бичиг баримтыг цахимжуулж, блокчэйн технологиор баталгаажуулна.

4. Аялал жуулчлал ба "Үлэг гүрвэлийн соёл"

Эрээн боомтыг зөвхөн ачаа тээврийн бус, аялал жуулчлалын төв болгохыг зорьж байна.

- **Хил орчмын аялал жуулчлал:** Монгол Улсаас ирэх жуулчдад зориулсан визний хөнгөлөлттэй нөхцөл, хил дээрх дэлгүүр (Duty-free) болон амралт зугаалгын цогцолбор (Үлэг гүрвэлийн парк)-ыг олон улсын стандартад хүргэнэ.

Эдийн засгийн хүлээгдэж буй үр дүн:

15 дугаар таван жилийн төлөвлөгөөний төгсгөлд (2030 он) Эрээн боомтоор нэвтрэх гадаад худалдааны нийт эргэлтийг **2025 оны түвшнээс 50%-аар нэмэгдүүлэх** зорилт тавьжээ.

Эрээн–Замын-Үүдийн хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс (CECZ)-ийг "Нэг бүс, олон цогцолбор" гэсэн загвараар хөгжүүлэхээр тусгасан.

2026 оны 2-р сарын шинэчилсэн төлөвлөгөөнд энэ бүсэд дараах 4 чиглэлийн үйлдвэрлэлийг барихаар нарийвчлан заажээ:

1. Хөдөө аж ахуй, малын гаралтай түүхий эд боловсруулах

Энэ бол Монгол Улсын давуу талыг Хятадын технологитой холбох хамгийн гол хэсэг юм.

- **Мах боловсруулах үйлдвэр:** Монголоос гүн хөлдөөсөн эсвэл дулааны аргаар боловсруулсан мах импортолж, хиам, консерв болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн болгон савлах үйлдвэрүүд.
- **Ноос, ноолуурын анхан шатны болон гүн боловсруулалт:** Ноос угаах, самнах, улмаар бэлэн бүтээгдэхүүн (утас, сүлжмэл эдлэл) хийх үйлдвэрлэлийн шугамууд.
- **Тэжээлийн үйлдвэр:** Монголын хөдөө аж ахуйн дайвар бүтээгдэхүүнийг ашиглан малын тэжээл үйлдвэрлэх бааз.

2. Импортын түүхий эдэд суурилсан хөнгөн үйлдвэр

- **Мод боловсруулах үйлдвэр:** ОХУ-аас Эрээнээр дамжин орж ирэх модыг боловсруулж, тавилга болон барилгын материал үйлдвэрлэх.
- **Уул уурхайн тоног төхөөрөмжийн угсралт:** Монголын уул уурхайн салбарт (Тавантолгой, Оюутолгой гэх мэт) хэрэгцээтэй байгаа машин механизмын сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний төвүүд.

3. Шинэ эрчим хүч ба Цахим төхөөрөмжийн угсралт

2026 оноос "Ногоон эдийн засаг"-ийг дэмжих хүрээнд дараах үйлдвэрүүдийг барихаар төлөвлөж байна:

- **Литийн батарей болон нарны хавтангийн угсралт:** Монгол руу экспортлох болон бүс нутгийн хэрэгцээнд зориулсан сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжүүд.
- **Гэр ахуйн цахилгаан барааны "SKD" (Хагас угсралт):** Хятадын өмнөд мужуудаас эд ангиудыг нь авчирч, Эрээнд угсран Монгол болон Төв Азийн зах зээлд гаргах.

4. Олон улсын логистик ба "Хүйтэн хэлхээний" хадгалалт

Үйлдвэрлэлээс гадна бүтээгдэхүүний чанарыг хадгалах дэд бүтцэд онцгой анхаарч байна.

- **Cold Storage (Хөлдөөгчтэй агуулах):** Мах, жимс, хүнсний ногоо хадгалах зориулалттай Өвөр Монголын хамгийн том хөлдөөгчтэй агуулахын цогцолбор.
- **Цахим худалдааны (E-commerce) логистикийн төв:** Монгол Улсын онлайн худалдааны захиалгуудыг ангилах, савлах автомат төвүүд.

Бүсэд олгох хөнгөлөлтүүд (2026-2030):

Төлөвлөгөөнд тусгагдсанаар эдгээр үйлдвэрүүдэд ажиллах **Монгол ажилчдын квотыг нэмэгдүүлэх**, хилээр нэвтрэх үйл явцыг хөнгөвчлөх "Цахим үнэмлэх" олгох асуудлыг хэлэлцэж байгаа юм байна.

-Монгол Улсад хамааралтай байж болох авто замын талаар-

1. "Босоо тэнхлэгийн" хурдны замын холболтууд

Монгол Улсын хилийн боомтуудаас Хятадын дотоод муж, хотууд руу чиглэсэн ачаа тээврийг хурдасгах зорилгоор дараах замуудыг барьж байна:

- **Ганцмод – Баяннуур (Linhe) чиглэлийн хурдны зам:** * **Баримт:** Энэхүү замын өргөтгөлийг 2026-2027 онд дуусгаж, Ганцмод боомтоос Хятадын үндэсний хурдны замын сүлжээ (G7 болон G6) руу шууд холбогдох гарцыг сайжруулна.
 - **Зорилт:** Нүүрс тээврийн авто машины дарааллыг арилгаж, өдөрт нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог 35%-иар нэмэгдүүлэх.
- **Шивээхүрэн – Сэхээ – Ганьсү чиглэлийн зам:**
 - **Баримт:** Шивээхүрэн боомтоос Ганьсү мужийн Жиучуань (Jiuquan) чиглэлд шинээр тавигдах хүнд даацын авто замын төсөл 15-р таван жилд тусгагдсан. Энэ нь Монголын баруун

бүсийн ашигт малтмалыг Хятадын төв болон баруун бүсийн үйлдвэрүүдэд хүргэх хамгийн дөт зам юм.

2. Боомт хоорондын "Хэвтээ тэнхлэгийн" холболт (S311 зам)

Өвөр Монголын талаас Монголтой хиллэдэг боомтуудыг хооронд нь холбосон хилийн дагуух S311 дугаартай авто замын шинэчлэлийг 2026 онд эрчимжүүлнэ.

- **Чиглэл: Эрзэн — Ханги — Ганцмод — Шивээхүрэн.**
- **Ач холбогдол: Хэрэв аль нэг боомтод ачаалал ихэсвэл ачааг хурдан хугацаанд нөгөө боомт руу шилжүүлэх логистикийн уян хатан байдлыг хангах.**

3. "Ухаалаг ба Ногоон" тээврийн дэд бүтэц (2026 оны шинэчлэл)

Төлөвлөгөөнд замын чанараас гадна тээврийн төрөлд томоохон өөрчлөлт оруулсан:

- **AGV (Жолоочгүй тээвэр) тусгай зам: Ганцмод болон Шивээхүрэн боомтуудад хил дамнасан жолоочгүй тээврийн хэрэгсэл (AGV) явах тусгай зориулалтын бетон замуудыг 15-р таван жилийн эхний хагаст барьж дуусгана.**
- **Цахилгаан ачааны машины цэнэглэх станцууд: Хил дамнасан тээврийг "ногоон" болгох үүднээс боомт дагуух авто замууд дээр цахилгаан ачааны машин цэнэглэх болон батерей солих (Battery Swapping) 50 гаруй станцыг барихаар төлөвлөсөн.**

4. Зүүнхатавч – Улаанхад – Жинжоу коридор

Монголын зүүн бүс (Бичигт боомт)-өөс ирэх ачааг далайн боомтод хүргэх авто замын коридор.

- **Төсөл: Зүүнхатавч боомтоос Улаанхад (Chifeng) хот хүртэлх өндөр зэрэглэлийн авто замыг шинэчилж, Монголын мах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг Хятадын далайн эргийн мужуудад 48 цагийн дотор хүргэх сүлжээ байгуулна.**

Мэдээллийн эх сурвалжууд:

www.nmg.gov.cn (Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын Засгийн газрын албан ёсны вэбсайт)

<http://jtyst.nmg.gov.cn> (Өвөр Монголын тээврийн газар)

<http://fgw.nmg.gov.cn/> (Эдийн засаг, хөгжил шинэчлэлийн хороо)

mn.cctv.com (Өвөр Монголын мэдээнүүдээс)

<https://graph.mn/news/4085>

<https://www.news.cn/politics/20260313/085af5de5a4b4268aa7d87d90817df2f/c.html>

<https://www.abg.gov.cn/eportal/ui?pagelId=e6671ac9d21949249d4ddf591dd94e5d&articleKey=f668043b3307436fb2ce53f6758729d5&columnId=b0c9e83fbf414eae961c861167111788>

Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын Засгийн газраас "Өвөр Монголын Өөртөө Засах Орны үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн 15 дахь таван жилийн төлөвлөгөөний тойм"-ыг гаргах тухай мэдэгдэл

Эх сурвалж: Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын Засгийн газар; Нийтлэгдсэн огноо: 2026-03-06

Хятад судлаач, доктор Х.Баатархүү 15-таван жил тойм